**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

“Баян-Уул суман дахь сум дундын ойн анги” ОНӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2026/008/НА-СТА-ОНӨҮГ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дорнод аймаг<br>2026 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Нармандах<br>Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК<br>Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг<br>Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ....................3

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН....................5

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.............**Error! Bookmark not defined.**

4. АУДИТЫН ТАЙЛАН..........**Error! Bookmark not defined.**

4.1 Ерөнхий зүйл..........**Error! Bookmark not defined.**

4.2 Материаллаг байдал..........**Error! Bookmark not defined.**

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал **Error! Bookmark not defined.**

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.........**Error! Bookmark not defined.**

4.5 Ерөнхий чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүн...........**Error! Bookmark not defined.**

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..**Error! Bookmark not defined.**

4.5.1 Завсрын аудитын талаар..........**Error! Bookmark not defined.**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.............**Error! Bookmark not defined.**

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....................8

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....................9

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ААТҮГ | Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| ОНӨҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг. 21000
Утас: 7058-4203

2026.03.13 № 360

танай ____________-ны № ______________-т

"БАЯН-УУЛ СУМАН ДАХЬ СУМ ДУНДЫН ОЙН АНГИ" ОНӨҮГ-ЫН ДАРГА Б.ЭРДЭНЭЖАРГАЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Баян-Уул суман дахь сум дундын ойн анги" ОНӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, ашиг алдагдлыг төлөвлөн батлуулаагүй, санхүүгийн тайланг аж ахуйн нэгж байгууллагын тайлангийн маягтаар бэлтгээгүй, төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар бэлтгэсэн байна.

**Аудитын гол асуудлууд**

Тус байгууллага нь орон нутгийн төсвөөс санхүүжилт авч үйл ажиллагаагаа явуулдаг ба нийт орлого 236,091.2 мянган төгрөгийн 5.4 хувь нь өөрийн үйл ажиллагааны орлогоос бүрдсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн жилийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 43 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 95.6 хувиар тайлагнасныг Аймгийн засаг даргын тамгын газраас 88.2 хувиар дүгнэсэн байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

2126050199

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | Хөрөнгө | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | - | - |
| 1.1.2 | Дансны авлага | - | - |
| 1.1.6 | Бараа материал | 374,588,838.21 | 425,742,213.21 |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 374,588,838.21 | 425,742,213.21 |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 1,447,882,272.24 | 1,296,725,868.04 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 74,304,375.00 | 74,116,875.00 |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 1,447,882,272.24 | 1,296,725,868.04 |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,822,471,110.45** | **1,722,468,081.25** |
| 2.1.1.1 | Дансны өглөг | | |
| 2.1.1.3 | Татварын өр | | |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн  өглөг | | |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | | |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | | |
| 2.3 | Өмч | | |
| 2.3.1 | төрийн | 102,710,325.00 | 102,710,325.00 |
| 2.3.2 | хувийн | | |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 16,884,059.27 | 16,884,059.27 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 1,702,876,726.18 | 1,602,873,696.98 |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 1,822,471,110.45 | 1,722,468,081.25 |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **1,822,471,110.45** | **1,722,468,081.25** |

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(Төгрөгөөр)

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 3,000,000.00 | 12,794,340.00 |
| 2 | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | - | - |
| 3 | Нийт ашиг ( алдагдал) | - | - |
| 4 | Түрээсийн орлого | - | - |
| 5 | Хүүний орлого | - | - |
| 6 | Ногдол ашгийн орлого | - | - |
| 7 | Татаас санхүүжилт | 151,685,400.00 | 225,623,360.00 |
| 8 | Бусад орлого | 1,217,723,381.00 | 111,546,539.00 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | - | - |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 223,005,798.92 | 445,442,918.20 |
| 11 | Санхүүгийн зардал | - | - |
| 12 | Бусад зардал | - | - |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний  олз (гарз) | - | - |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | (9,606,350.00) |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн  олз (гарз) | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 17 | Бусад ашиг ( алдагдал) | - | - |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **-** | **-** |
| 19 | Орлогын татварын зардал | - | - |
| **20** | **Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)** | **-** | **-** |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | - | - |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал) | - | - |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - | - |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - |
| 23.3 | Бусад олз (гарз) | - | - |
| 24 | Нийт дэлгэрэнгүй орлогын дүн | 1,149,402,982.08 | (105,085,029.20) |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | - | - |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

| № | ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | 2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 102,710,325.00 | 16,884,059.27 | 553,473,744.10 | 673,068,128.37 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | - |
| **3** | Залруулсан үлдэгдэл | - | - | - | - |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | 1,149,402,982.08 | 1,149,402,982.08 |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - |
| **9** | 2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 102,710,325.00 | 16,884,059.27 | 1,702,876,726.18 | 1,822,471,110.45 |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | - |
| **11** | Залруулсан үлдэгдэл | | | - | - |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | (100,003,029.20) | (100,003,029.20) |
| **17** | **2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **102,710,325.00** | **16,884,059.27** | **1,602,873,696.98** | **1,722,468,081.25** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн | - | - |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | - | - |
| 1.1.3 | Үндсэн үйл ажиллагааны орлого | 3,000,000.00 | 12,794,340.00 |
| 1.1.4 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 141,273,900.00 | 223,296,900.00 |
| 1.2 | Бусад татаас орлого | 10,411,500.00 | 2,326,460.00 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 115,457,600.00 | 181,883,574.97 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 15,300,700.00 | 20,548,500.00 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 9,569,300.00 | 5,911,980.00 |
| 1.2.4 | Ашиглалтын зардал төлсөн | - | - |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 4,302,000.00 | 6,427,520.00 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 277,673.50 | 171,000.00 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 287,662.00 | 98,010.00 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 9,490,464.50 | 23,377,115.03 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | - | - |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн | 154,685,400.00 | 238,417,700.00 |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| 2.1.2 | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | - | - |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн | 154,685,400.00 | 238,417,700.00 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | - | - |
| 3 | Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн | - | - |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | - |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн | - | - |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | - | - |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | - | - |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | - | - |
| 4 | Валютын ханшийн зөрүү | - | - |
| 4.1 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

(Төгрөгөөр)

| Үзүүлэлт | 2024 оны гүйцэтгэл | Зөрүү | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
| Татаас санхүүжилтийн орлого | 151,685,400.00 | 223,296,900.00 | 225,623,360.00 | 2,326,460.00 | 99.0 |
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 3,000,000.00 | 12,000,000.00 | 12,794,340.00 | 794,340.00 | 93.8 |
| Бусад орлого | 1,217,723,381.00 | - | 111,546,539.00 | 111,546,539.00 | - |
| **НИЙТ ОРЛОГЫН ДҮН** | **1,372,408,781.00** | **235,296,900.00** | **349,964,239.00** | **114,667,339.00** | 67.2 |
| Цалин хөлс | 114,067,951.64 | 194,386,600.00 | 180,883,574.97 | (13,503,025.03) | 107.5 |
| АО-аас НД-шимтгэлд төлөх зардал | 14,890,348.36 | 20,548,500.00 | 20,548,500.00 | - | 100.0 |
| Хангамжийн бараа материалын зардал | 27,864,300.00 | 13,066,800.00 | 18,161,733.00 | 5,094,933.00 | 71.9 |
| Дотоод томилолт | 1,800,000.00 | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Байр ашиглалттай зардал | 4,051,188.92 | 3,000,000.00 | 2,978,911.50 | (21,088.50) | 100.7 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | 2,047,335.50 | 995,000.00 | 709,010.00 | (285,990.00) | 140.3 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 14,870,000.00 | 2,300,000.00 | 13,661,850.00 | 11,361,850.00 | 16.8 |
| Хөрөнгө данснаас хассаны гарз | - | - | 9,606,350.00 | 9,606,350.00 | |
| Элэгдлийн зардал | 39,457,398.92 | - | 186,762,068.20 | 186,762,068.20 | |
| **НИЙТ ЗАРДЛЫН ДҮН** | **219,048,523.34** | **235,296,900.00** | **434,311,997.67** | **12,253,029.47** | 54.2 |
| **ТАТВАР** | - | - | - | - | |
| **ТАТВАРЫН ДАРААХ АШИГ** | **1,153,360,257.66** | **0.00** | **-84,347,758.67** | **102,414,309.53** | |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 5,082.0 мянган төгрөгийн дараах 1 алдааг[1] аудитын явцад залруулав. Үүнд:

1. Блок материалыг зарлагдан хашаа барилсан 5,082.0 мянган төгрөгийг шууд зардалд бүртгэснийг орлого болгож залруулсан нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлагналын толилуулга", санхүүгийн тайлагналын “Үнэлгээ ба хуваарилалт”, “Толилуулга” зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, эздийн өмчийн тайланд нэмж залруулав.

Мөн аудитаар 2 зөвлөмж өгөв

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 303.7 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өгөв.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Санхүүгийн тайлангийн маягттай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Санхүүгийн тайланг аж ахуйн нэгж байгууллагын тайлангийн маягтаар бэлтгээгүй, төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар бэлтгэсэн нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт "Санхүүгийн тайлангийн маягт" дагуу бэлтгэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

[1] *Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглэлээгүй орхисон/,*

*Өгсөн зөвлөмж:*

Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3 дахь заалтыг баримтлан, санхүүгийн тайлангийн маягтаар бэлтгэх.

### 2. *Эзэмшигчийн өмчтэй холбоотой асуудал*

*2.1. Илрүүлэлт:*

Байгууллагын гэрчилгээ дээрх өмчийн дүн 4,921.3 мянган төгрөг, санхүүгийн тайлан дээрх өмчийн дүнгээс 102,710.3 мянган төгрөг ба 97,789.0 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 болон 13.1 дэх заалтыг баримтлан, улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх дүн, санхүүгийн тайлан дахь өмчийн дүнг адил болгох.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Блок материалыг зарлагдан хашаа барилсан 5,082.0 мянган төгрөгийг шууд зардалд бүртгэснийг орлого болгож залруулсан | 1 | 5,0820.0 | | | 1 | 5,0820.0 | 1 | 5,0820.0 | | | | |
| Дүн | **1** | **5,0820.0** | | | **1** | **5,0820.0** | **1** | **5,0820.0** | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар | | | | | | | | | | | | |
| Санхүүгийн тайланг аж ахуйн нэгж байгууллагын тайлангийн маягтаар бэлтгээгүй, төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар бэлтгэсэн | 1 | - | | | | - | 1 | - | | | | |
| Байгууллагын гэрчилгээ дээрх өмчийн дүн 4,921.3 мянган төгрөг, санхүүгийн тайлан дээрх өмчийн дүнгээс 102,710.3 мянган төгрөг ба 97,789.0 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн | 1 | - | | | | - | 1 | - | | | | |
| **Дүн** | **2** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **2** | | **-** | - | - | - |